



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/443

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3, Ахмад настны тухай хуулийн 11.1.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 4-р сарын 27-ны ээлжит XIV тогтоол, 2022 оны 12-р сарын 02-ны ээлжит бус VIII тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн биеийн тамир спортын газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Монголын ахмад мастеруудын VII их наадмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг олгосугай.
2. Дээрх зардлын 10,000,000 (Арван сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны "Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"-аас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн), аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Д.Балжинням) нарт зөвшөөрсүгэй.
3. Олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулахыг Биеийн тамир спортын газрын дарга (Б.Очирбат)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

